



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 138

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасаж үнэлгээг
бууруулан бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны 2020 оны 02-06/3139 дүгээр мэдэгдлийн дагуу Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн биет бус хөрөнгөд бүртгэлтэй 16,367 м.кв бүхий газар эзэмших эрхийг 16,354 м.кв болгон 13 м.кв-аар үнэлгээг 420,940.00 (дөрвөн зуун хорин мянга есөн зуун дөчин) төгрөгөөр тус тус бууруулан бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн захирал Ч.Чимэдрагчаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийн үнэлгээг бууруулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан тайлагнах.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ